



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/82

Улаан-Уул

Байн-Ам 2 дугаар баг, Худаг-Урт
4 дүгээр баг, Бийрийн уулзвар 5 дугаар
багуудын бэлчээрийг чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1, Газрын тухай хуулийн 52 зүйлийн 52.2, сумын 2, 3, 4, 6 дугаар багийн Иргэдийн нийтийн хурлын тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэр дэх малын тоо толгой, бэлчээрийн даац, багтаамжтай уялдуулан 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэл малтай өрх нутаглах, мал бэлчээрлүүлэхээс чөлөөлөх нутаг, бэлчээрийг хавсралтаар баталсугай.

2.Бэлчээр нутаг чөлөөлөх, хамгаалах цаашид бэлчээр ашиглалтыг сайжруулах чиглэлээр малчин мал бүхий иргэдтэй хамтарч ажиллах, тэдний санал бодлыг орон нутгийн бодлогод тусган хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг (О.Энхболд), Мал эмнэлгийн тасаг (О.Намжирмаа), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Аймгийн Засаг даргын мал, амьтны отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах малчин өрхийг татаж журам батлах тухай 2022 оны 06 дугаар сарын 06 -ны өдрийн А/380 дугаар захирамжийн хүрээнд "Түр журам"-ыг мөрдөн чөлөөлсөн нутаг бэлчээрт гадны аймаг, сумдаас отор нүүдлээр ирж байгаа малчдыг сумын нутаг дэвсгэрт буулгахгүй, хөлөөр зорчуулахгүй байх талаар хамтран ажиллахыг нийт малчдад уриалсугай.

4.Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа болон бусад нутаг бэлчээрийг хувийн ашиг сонирхлын үүднээс тохиролцож айл буулгах, түрээслэх, наймаалах зэрэг зөрчил дутагдлыг тухай бүр нь зогсоож, зөрчил гаргасан тохиолдолд эзэмшлийн гэрчилгээг хүчингүй болгох болон хуулийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг (О.Энхболд), Газрын даамал (Т.Сэвжиддулам) нарт даалгасугай.

642201147

2.

5.Сумын төвийн байгууллага, айл өрхийн ногоон байгууламжийг хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах хүрээнд Шаргалжуут голын гүүрнээс доош цэвэрлэх байгууламж хүртэл голын зүүн тал болон сумын төвд малтай айл байхыг хориглосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Т.Мөнхжаргал) нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ

Сумын Засаг даргын 2022 оны
A.89 06 сарын 22-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ЧӨЛӨӨЛӨХ НУТАГ БЭЛЧЭЭР

2 дугаар багт: Нарийн худаг, Гашуун худаг, Гашуун, Цагаан хавцгай, Шанд,
Адгийн хар, Хөх дэл

3 дугаар багт: Ёлын амаас дээш Их Ангал хүртэлх голын хойд тал

4 дүгээр багт: Засмал замаас дээш Асгат ам хүртэлх нутаг , Хөх ус, Гурван
Ангал, Улаан адгайн Тоглоомтоос дээш,

-----o0o-----